МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 22 өдөр Дугаар А/408 Мандалговь

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх
шийдвэрт өөрчлөлт оруулах тухай

"Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль"–ийн 5.1.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. ITRF-97 солбицолын тогтолцоонд хийгдсэн кадастрын зургийг UTM тусгагт хөрвүүлэхэд систем хоорондын зөрүүнээс үүдэж эдлэн газрын кадастрын зургийн талбайн хэмжээ зөрүүтэй гарч байгаа болон Хаягжуулалтын тухай хуулийн дагуу шинэ хаяг авсан 4 нэгж талбарын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Кадастрын зургийн талбайн хэмжээ, хаягийн өөрчлөлтийг аливаа шилжилт хөдөлгөөн хийлгэхээр газар өмчлөгч хүсэлт гаргасан тухай бүр шийдвэрлүүлж газрын улсын бүртгэлд өөрчлөлт оруулах иргэд олон нийтэд мэдээлэл өгч ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга (Р.Мөнхтогтох), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж) нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Газрын талбайн хэмжээний өөрчлөлтийг тухай бүр гарсан шийдвэрийг үндэслэн газар өмчлөгч иргэдэд хүндрэл, чирэгдэлгүй, хууль тогтоомжид заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Улсын бүртгэл хэлтэс (Ж.Өлзийжаргал)-т үүрэг болгосугай.

Дөрөв. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2006 оны 10 дүгээр захирамжийн хавсралтын 107, 2008 оны 421 дугаар захирамжийн хавсралтын 3, 2005 оны 319 дүгээр захирамжийн хавсралтын 680 дэх заалтуудыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ

488191137

Дундговь аймгийн Засаг даргын 2019 оны 11 дугаар сарын 22-ны өдрийн А/408 дугаар захирамжийн хавсралт

| № | Өмчлөгчийн | | | Өмнөх захирамжийн | | Өмнөх газрын | | Газрын | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Овог | Нэр | Регистрийн дугаар | Огноо дугаар | Холбогдох хэсгийн дугаар | Байршил | Хэмжээ /м2/ | Хэмжээ /м2/ | Байршил | Үнэ /төгрөг/ |
| 1 | Баранхүү | Сандагсүрэн | ЗИ68010111 | | | Мандал 18-1в | 1200 | 1394 | Мандал 20-2012 | 4460800 |
| 2 | Цэдэв | Сугарцолмон | ЗК63113003 | | | Нарлаг 1-6 | 1029 | 1107 | Нарлаг 6-618 | 3542400 |
| 3 | Нанзад | Болор-Эрдэнэ | ЗМ81110614 | | | Мандал 2-16 | 728 | 844 | Мандал 1-138 | 2700800 |
| 4 | Маам | Амарсайхан | ЗК79120704 | | | Айраг 4-31а | 825 | 940 | Айраг 4-474 | 3008000 |